

**БАРИЛГЫН НОРМАТИВ БАРИМТ БИЧГИЙН ТОГТОЛЦОО**  
**МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН НОРМ БА ДҮРЭМ**

**СЭДЭВЧИЛСЭН ГАЗРЫН ЗУРАГ,  
АТЛАСТ НЭГ МАЯГИЙН СУУРЬ  
АШИГЛАХ**

**БНБД 18-....-02**

**МОНГОЛ УЛСЫН БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН ЯАМ**

Улаанбаатар хот

2018 он

---

# МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН НОРМ БА ДҮРЭМ

---

## СЭДЭВЧИЛСЭН ГАЗРЫН ЗУРАГ АТЛАСТ НЭГ МАЯГИЙН СУУРЬ АШИГЛАХ

---

### 1. Ерөнхий хэсэг

**1.1.** Энэхүү норм ба дүрэм нь сэдэвчилсэн газрын зураг, атлас зохиоход нэг маягийн суурийг ашиглахтай холбогдох харилцааг зохицуулна.

### 2. Ишлэл

Энэ дүрмийг дараах баримт бичгийг ишлэл болгож ашигласан бөгөөд Газрын зургийн нэг маягийн суурийг ашиглахад мөрдөх албан ёсны стандарт болно.

Ишлэл болгон ашигласан баримт бичгүүдэд өөрчлөлт орох нь энэ стандартыг шинэчлэх шаардлага болж чадна.

2.1. “Геодези, зураг зүйн тухай хууль”- 1997 он;

### 3. Газрын зургийн нэг маягийн суурийн зориулалт

3.1. Ерөнхий газарзүйн элементүүдийг агуулсан тухайн масштабын нийтийн хэрэгцээнд зориулагдсан төрөл бүрийн сэдэвчилсэн газрын зураг, атлас зохиож хэвлэх, газрын зургийн зохиолтын ажлыг чанаржуулах зорилгоор зохиогдсон газарзүйн суурийг нэг маягийн суурь гэнэ.

3.2. Нэг маягийн суурийг ашиглан жижиг масштабын бүх төрлийн сэдэвчилсэн газрын зураг, атлас зохионо.

### 4. Газрын зургийн нэг маягийн суурийн агуулга

4.1. Сэдэвчилсэн газрын зургийн нэг маягийн суурь нь 1:500 000-аас жижиг масштабээр зохиосон байна.

4.2. Нэг маягийн суурь дараах агуулгатай байна.  
*/Хүснэгт1/*

4.3. Тухайн газрын зураг, атласын сэдэв, зориулалт, агуулгаас хамаарч энэ дүрмийн 4.2. дахь заалтад орсон элементүүдийг ерөнхийлж зарим нэг элементийг үзүүлэхгүй байж болно.

## **5. Газрын зургийн нэг маягийн суурь ашиглах**

5.1. Сэдэвчилсэн газрын зураг атласын нэг маягийн суурь зохиох ажлыг Зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага /ГЗБГЗЗГ/ гүйцэтгэнэ.

5.2. Зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь сэдэвчилсэн газрын зураг, атласын нэг маягийн суурийг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр дамжуулан нийтийн хэрэглээнд ашиглуулна.

5.3. Зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэхүү нэг маягийн сууриудын агуулгад орсон өөрчлөлт, шинэчлэлийг тухай бүрт оруулан, өөрчлөлт хийсэн цаг хугацаа, эх үүсвэрийг зайлшгүй дурьдана. 5 жил тутам шинэчилнэ.

5.4. Зураг зүйн тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж нь сэдэвчилсэн газрын зураг, атлас зохиохдоо Нэг маягийн суурийг Зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Архив мэдээллийн төв /АМТ/-с зохих журмын дагуу авч ашиглана.

## **6. Газрын зургийн нэг маягийн суурь ашиглан газрын зураг, атлас зохиох**

6.1 Иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагууд газрын зураг, атлас зохиох, нийтийн хүртээл болгох хүсэлтээ Зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, тухайн ажил өмнө нь хийгдсэн эсэхийг хянуулна.

6.2 Зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн хүсэлтийг хүлээн авч энэхүү газрын зураг, атлас нь өмнө хийгдсэн эсэхийг зураг зүйн бүтээлийн мэдээллийн сангаас шүүж, эргэн мэдээлнэ.

6.3 Зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын мэдээллийн санд байхгүй газрын зураг, атлас зохиох тохиолдолд хүсэлт гаргагч хуулийн этгээд нь ажлын даалгавар боловсруулж, Зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн болон тухайн мэргэжлийн зөвлөх инженерээр хянуулж баталгаажуулна.

6.4 Баталгаажсан ажлын даалгаврыг үндэслэн хүсэлт гаргасан иргэн, аж ахуй нэгж нь газрын зураг, атласыг Зураг зүйн тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлнэ.

6.5 Төрийн байгууллага, төсөл, сангийн хөрөнгөөр хийгдэж буй газрын зураг, атласыг зохиож, хэвлүүлэхдээ

Зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрлийг авч 6.4-д зааснаар гүйцэтгүүлнэ.

6.6. Зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн газрын зургийн нэг маягийн суурь ашиглан зохиосон газрын зураг, атласад дараах шалгалтын хийнэ. Үүнд:

6.6.1. Нэг маягийн суурь ашигласан эсэх;

6.6.2. Нэг маягийн суурийн агуулга тухайн зургийн сэдэв, агуулга, зориулалттай нийцсэн эсэх

6.6.3. Газрын зураг, атласын эхийг зохиохдоо нэг маягийн суурьтай холбоотой норм, дүрэм, стандартыг ашигласан эсэх

## **7. Газрын зургийн нэг маягийн суурьт жижүүрлэлт хөтлөх, хадгалалт, архивлалт**

7.1. Сэдэвчилсэн газрын зураг, атласын нэг маягийн суурьт энэ дүрмийн 5.3-д заасны дагуу жижүүрлэлтийг зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн хөтөлж, Зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын архивд зохих журмын дагуу хүлээлгэн өгнө;

7.2. Сэдэвчилсэн газрын зураг, атласын нэг маягийн суурь нь Зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын архивд /Архив мэдээллийн төв/-д хадгалагдана.

## **8. Хариуцлага**

8.1 Газрын зургийн нэг маягийн суурийн үнэн зөв эсэх, шинэчлэлт, өөрчлөлт хийсэн эсэхийг түүнийг шалгаж хүлээн авсан этгээд хариуцна.

8.2. Сэдэвчилсэн газрын зураг, атласыг дур мэдэн зохиох, батлагдсан нэг маягийн суурийг ашиглаагүй, энэ дүрмийн 6.4-г зөрчсөн тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Хүснэгт1

1:500 000, 1:1 000 000,1:1500 000, 1:2500 000, 1:3 000 000, 1:5 000 000, 1:6 000 000, 1:9 000 000, 1:12 000 000-ны масштабтай нэг маягийн суурийн агуулга

<b>Агуулга</b>	<b>1:500000</b>	<b>1:1000000</b>	<b>1:1500000</b>	<b>1:2500000</b>	<b>1:3000000</b>
<b>Хил</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Улс</li> <li>• Аймаг, хот</li> <li>• Сум, дүүрэг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Улс</li> <li>• Аймаг, хот</li> <li>• Сум, дүүрэг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Улс</li> <li>• Аймаг, хот</li> <li>• Сум,</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Улс</li> <li>• Аймаг, хот</li> <li>• Сум</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Улс</li> <li>• Аймаг, хот</li> <li>• Сум</li> </ul>
<b>Суурин газрууд</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хот, аймгийн төв</li> <li>• Сум, багийн төв</li> <li>• Томоохон суурин газрууд</li> <li>• Уурхай</li> <li>• Хилийн гарц</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хот, аймгийн төв</li> <li>• Сум, багийн төв</li> <li>• Томоохон суурин газрууд</li> <li>• Уурхай</li> <li>• Хилийн гарц</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хот, аймгийн төв</li> <li>• Сум, багийн төв</li> <li>• Томоохон суурин газрууд</li> <li>• Уурхай</li> <li>• Хилийн гарц</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хот, аймгийн төв</li> <li>• Сумын төв</li> <li>• Хилийн гарц</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хот, аймгийн төв</li> <li>• Сумын төв</li> <li>• Хилийн гарц</li> </ul>
<b>Зам харилцаа</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Төмөр зам</li> <li>• Хатуу хучилттай зам</li> <li>• Сайжруулсан хөрсөн зам</li> <li>• Ердийн хөрсөн зам</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Төмөр зам</li> <li>• Хатуу хучилттай зам</li> <li>• Сайжруулсан хөрсөн зам</li> <li>• Ердийн хөрсөн зам</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Төмөр зам</li> <li>• Хатуу хучилттай зам</li> <li>• Сайжруулсан хөрсөн зам</li> <li>• Ердийн хөрсөн зам</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Төмөр зам</li> <li>• Хатуу хучилттай зам</li> <li>• Сайжруулсан хөрсөн зам</li> <li>• Ердийн хөрсөн зам</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Төмөр зам</li> <li>• Хатуу хучилттай зам</li> <li>• Сайжруулсан хөрсөн зам</li> </ul>

<b>Ус зүй</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Гол мөрөн</li> <li>• Нуур тойром</li> <li>• Худаг булаг</li> <li>• Намаг</li> <li>• Хужир, марз</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Гол мөрөн</li> <li>• Нуур тойром</li> <li>• Худаг булаг</li> <li>• Намаг</li> <li>• Хужир, марз</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Гол мөрөн</li> <li>• Нуур тойром</li> <li>• Худаг булаг</li> <li>• Намаг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Гол мөрөн</li> <li>• Нуур тойром</li> <li>• Намаг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Гол мөрөн</li> <li>• Нуур тойром</li> <li>• Намаг</li> </ul>
<b>Газрын гадарга</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хаялбар</li> <li>• Элс</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хаялбар</li> <li>• Элс</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хаялбар</li> <li>• Элс</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хаялбар</li> <li>• Элс</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хаялбар</li> <li>• Элс</li> </ul>
<b>Хаялбар</b>	550 600 650 700 750 800 850 900 950 1000 1050 1100 1150 1200 1250 1300 1350 1400 1450 1500 1550 1600 1650 1700 1750 1800 1850 1900 1950 2000 2050 2100 2150 2200 2250 2300 2350 2400 2450 2500 2600 2700 2800 2900 3000 3100 3200 3300 3400 3500 3600 3700 3800 3900	500 600 700 800 900 <b>1000</b> 1200 1400 1600 1800 <b>2000</b> 22002400 26002800 <b>3000</b> 3200 34003600 3800 <b>4000</b> 42004400 46004800	600 800 1000 1400 <b>1800</b> 2200 2600 3000 3400 <b>3800</b> 4200 4600	500 1000 1500 2000 2500 3000 3500 4000	500 1000 1500 2000 2500 3000 3500 4000

	4000 4100 4200 4300				
	57 хаялбар	27 хаялбар	27 хаялбар	8 хаялбар	8 хаялбар

<b>Агуулга</b>	<b>1:5000000</b>	<b>1:6000000</b>	<b>1:9000000</b>	<b>1:12000000</b>
<b>Хил</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Улс</li> <li>• Аймаг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Улс</li> <li>• Аймаг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Улс</li> <li>• Аймаг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Улс</li> <li>• Аймаг</li> </ul>
<b>Суурин газрууд</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хот, аймгийн төв</li> <li>• Сумын төв</li> <li>• Хилийн гарц</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хот, аймгийн төв</li> <li>• Сумын төв</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хот, аймгийн төв</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хот, аймгийн төв</li> </ul>
<b>Зам харилцаа</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Төмөр зам</li> <li>• Хатуу хучилттай зам</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Төмөр зам</li> <li>• Хатуу хучилттай зам</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Төмөр зам</li> </ul>	
<b>Ус зүй</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Гол мөрөн</li> <li>• Нуур</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Гол мөрөн</li> <li>• Нуур</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Гол мөрөн</li> <li>• Нуур</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Гол мөрөн</li> <li>• Нуур</li> </ul>
<b>Газрын гадарга</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Хаялбар</li> <li>• Элс</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Хаялбар</li> <li>• Элс</li> </ul>		

<b>Хаялбар</b>	500доош1000 1500 2000 2500 3000 3500 4000 дээш	500доош1000 1500 2000 2500 3000 3500 4000дээш		
	8 хаялбар 4 шатлал	8 хаялбар 4 шатлал		



